

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 7636 дугаарт бүртгэв

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар А/488

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ НЭВТРЭХ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 18 дахь хэсэг, Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2025 оны №001/ХТ2025/0068 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийх, сурталчлах болон нэвтрэх хураамжийг цахимжуулах зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх иргэний хураамжийн хэмжээг нэгдүгээр, тээврийн хэрэгслийн хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тусгай хамгаалалттай газар нутагт байнга оршин суудаг, ажилладаг иргэн, аж ахуйн нэгжийн зорчигч тээврийн хэрэгсэл болон тусгай зориулалтын авто замаар экспортын нүүрс тээвэрлэж буй ачаа тээврийн хэрэгслийн холбогдох баримтыг (иргэний үнэмлэх, ажлын үнэмлэх, тухайн байгууллагын албан хүсэлт) үндэслэн бүртгэж, хураамжгүйгээр нэвтрүүлсүгэй.

3.Тусгай хамгаалалттай газар нутагт аялах, амрах зорилготой нэвтэрч буй иргэний тухайн газар нутагт аялал үргэлжлэх хугацаанд нэг удаа энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан хэмжээгээр, бусад зорилгоор нэвтрэх, дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийг зорчигчийн тоо үл хамааран энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан тээврийн хэрэгслийн төрөл ангиллаар хураамж авахыг хамгаалалтын захиргаадын дарга нарт үүрэг болгосугай.

4.Нэвтрэх цэгийг цахимжуулсан газрууд тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх иргэн болон автотээврийн хэрэгслийн зорчигчийн тоо, нэвтрэх зорилгоос үл хамааран зөвхөн энэ тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан хэмжээгээр хураамжийг бүрдүүлсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, шат дараатай цахимжуулж, хяналт тавьж ажиллахыг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газар /Ц.Уранчимэг/-т даалгасугай.

6.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/844 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.САНДАГ-ОЧИР

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 5
дугаар сарын 26-ны өдрийн А/488 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт*

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ НЭВТРЭХ ИРГЭНИЙ
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Иргэний харьяалал	Төлбөрийн хэмжээ (төгрөг)			
	Дархан цаазат газар	Байгалийн цогцолборт газар	Байгалийн нөөц газар	Байгалийн дурсгалт газар
Монгол Улсын иргэн	5.000	3.000	2.000	1.000
Гадаад улсын иргэн	20.000	15.000	10.000	10.000

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 5
дугаар сарын 26-ны өдрийн А/488 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт*

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НЭВТРЭХ ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Тээврийн хэрэгслийн төрөл	Ангилал	Төлбөрийн хэмжээ (төгрөг)			
		Дархан цаазат газар	Байгалийн цогцолборт газар	Байгалийн нөөц газар	Байгалийн дурсгалт газар
Зорчигч тээврийн хэрэгсэл	8-аас илүүгүй хүний суудалтай	15.000	9.000	6.000	3.000
	8-12 хүртэл хүний суудалтай	50.000	30.000	20.000	10.000
	12-24 хүний суудалтай	90.000	54.000	36.000	18.000
	24-өөс дээш хүний суудалтай	120.000	72.000	48.000	24.000
Ачаа тээврийн хэрэгсэл	2 тэнхлэгтэй 3.5 тн хүртэл бодит жинтэй	20.000	15.000	10.000	8.000
	2 тэнхлэгтэй 3.5-18 тн хүртэл бодит жинтэй	30.000	20.000	12.000	10.000
	3 тэнхлэгтэй 18 тн хүртэл бодит жинтэй	35.000	25.000	15.000	12.000
	3 тэнхлэгтэй 18-25 тн хүртэл бодит жинтэй	40.000	30.000	20.000	14.000
	4-өөс дээш тэнхлэгтэй 25 тн хүртэл бодит жинтэй	45.000	35.000	25.000	16.000
	4-өөс дээш тэнхлэгтэй 25 тн-оос дээш бодит жинтэй	50.000	40.000	30.000	20.000
Нисдэг тэрэг, онгоц	5 хүртэл хүний суудалтай	300.000	100.000	80.000	60.000
	5-12 хүний суудалтай	400.000	200.000	160.000	120.000
	12-оос дээш хүний суудалтай	500.000	300.000	240.000	180.000
Бусад	Механизм	50.000	40.000	30.000	20.000
	Мотоцикл (4 дугуйт), моторт завь	15.000	9.000	6.000	3.000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 7637 дугаарт бүртгэв

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар А/649

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1, 12 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 36¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 1/2905 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутагт газар ашиглах эрх олгох “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогчид болон төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлох журам”-ыг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Журам батлах тухай” А/202 дугаар тушаал, 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” А/429 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд журмыг бүртгүүлж, хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газар /Ц.Уранчимэг/-т үүрэг болгосугай.

САЙД

Ц.САНДАГ-ОЧИР

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 6
дугаар сарын 30-ны өдрийн А/649 дүгээр тушаалын хавсралт*

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ
ЭРХ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧИД БОЛОН
ТӨСӨЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ
ЖУРАМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогчид болон төсөлд тавигдах нийтлэг шаардлагын журам” (цаашид “журам” гэх)-аар Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогчид (цаашид “оролцогч” гэх) тавигдах нийтлэг шаардлага болон төсөл хүлээн авах, сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан нэгж сонгон шалгаруулалтад оролцогчдоос төсөл хүлээн авах үйл ажиллагааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон энэ журмын дагуу зохион байгуулна.

1.3.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах сонгон шалгаруулалтад оролцогчдоос төсөл хүлээн авах үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, шударга өрсөлдөх, тэгш боломжоор хангах зарчмыг баримтлан зохион байгуулна.

ХОЁР.ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

2.1.Тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогч тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газарт хүсэлт гаргана.

2.2.Тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогч иргэн, хуулийн этгээд нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.2.1.тусгай хамгаалалттай газар нутгийн байршил, байгалийн унаган төрх, түүний онцлог хэв шинж байдалтай зохицсон төсөл ирүүлэх;

2.2.2.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд (гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид хамаарахгүй) байх;

2.2.3.тухайн төслийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлсон байх;

2.2.4. татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өргүй байх;

2.2.5. аялал жуулчлал, байгаль орчны чиглэлийн мэргэжлийн боловсон хүчинтэй байх;

2.2.6. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36².2.4-т заасан зард тусгасан тухайн газрын онцлог, шинж чанараас шалтгаалсан нэмэлт шаардлагыг хангасан байх.

ГУРАВ.ТӨСӨЛД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

3.1. Сонгон шалгаруулалтад оролцогч иргэн, хуулийн этгээдийн төсөл нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан газар ашиглалтын зориулалт болон газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

3.1.1. түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт хэв шинж, унаган төрх, ургамал, амьтны төрөл зүйл, амьдрах орчинд сөрөг нөлөөгүй, тэдгээрийг зохистой ашиглах, хамгаалах зорилгоор иргэд, олон нийтийн амрах, аялах, зугаалах, байгаль орчныг танин мэдэх, соёл, аялал жуулчлалын үзвэр, худалдаа үйлчилгээ, эрхлэх үйл ажиллагаанд нийцсэн байх;

3.1.2. газар ашиглалтын зориулалт нь газар зохион байгуулалтын төлөвлөгөө, аялал жуулчлалын бүс, орон нутгийн дунд, урт хугацааны хөгжлийн бодлого, чиглэлд нийцсэн нийгэм, соёл, эдийн засгийн өгөөжтэй байх;

3.1.3. байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горимд нийцүүлэн төлөвлөсөн байх;

3.1.4. тухайн газар нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, биет болон биет бус өв, соёл, түүхэн дурсгалт газар, биологийн олон янз байдал, байгалийн нөөцийн мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаагаа уялдуулсан байх;

3.1.5. тусгай хамгаалалттай газарт явуулах үйл ажиллагаа нь аялал жуулчлалын даац, нөөцийн судалгаанд үндэслэсэн аялагчдад зориулсан мэдээлэл, сурталчилгаа, бүтээгдэхүүн үйлчилгээтэй байх;

3.1.6. орон нутгийн нийгэм, эдийн засагт эерэг нөлөөтэй, тухайн нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийг баримталж, хамтын оролцоог дэмжсэн арга хэмжээг тусгасан байх;

3.1.7. төслөө “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500:2017 стандартын дагуу боловсруулсан байх.

3.2. Сонгон шалгаруулалтад оролцогч иргэн, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл нь байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль хамгаалах чиглэлээр дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

3.2.1.хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материалаар баригдсан, дулааны алдагдал багатай, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих;

3.2.2.байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөцийн хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч ашиглах, ногоон байгууламж нэмэгдүүлэх зэрэг ногоон технологийн шийдэл ашигласан байх;

3.2.3.ухаалаг эрчим хүчний удирдлагын систем, нарны хавтан зэрэг сэргээгдэх эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж ашигласан, нэгж талбайд ногдох эрчим хүчний хэрэглээг 20-иос доошгүй хувиар бууруулсан гэрэлтүүлэгтэй байх;

3.2.4.нар, салхи болон газрын гүний дулааныг ашиглах, дулаалгын материал, халаах, хөргөх болон агааржуулах систем зэрэг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологи, тоног төхөөрөмжтэй байх;

3.2.5.хог хаягдлыг дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ангилан ялгах менежмент хэрэгжүүлсэн байх;

3.2.6.хур тунадасны усыг хуримтлуулан ашиглах, усны хэмнэлттэй систем, ус хэмнэх тоног, төхөөрөмж ашигласан байх;

3.2.7.хаягдал ус цэвэрлэх байгууламжтай байх, хаягдал бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд дахин ашиглах боломжтой байх;

3.2.8.ургамал, ойн сэргэн ургах чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, төлөв байдлыг сайжруулах, мод бут тарих төлөвлөгөө, ногоон байгууламжтай байх.

3.3.Төсөл хэрэгжүүлэгч ашиглахаар хүсэлт гаргасан газарт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээний төлөвлөлт, түүнд зарцуулах зардлын тооцооллыг гаргасан төлөвлөгөөтэй байна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 7638 дугаарт бүртгэв

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 100, 60

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг, Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Б.ЭНХБАЯР

Төрийн албаны зөвлөлийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хамтарсан 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 100, 60 дугаар тушаалын хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ, ТҮҮНД ГОМДОЛ ГАРГАХ ЖУРАМ

/Шинэчилсэн найруулга/

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн албан хаагч /цаашид “албан хаагч” гэх/-д сахилгын шийтгэл ногдуулах, сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрт гомдол гаргахад энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнд шийтгэл ногдуулахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг баримтална.

1.3.Төрийн тусгай албан хаагчид ногдуулах сахилгын шийтгэлийн төрөл, хэмжээ, гомдол гаргах журмыг тусгайлан хуулиар зохицуулсан бол тухайн хуулийг баримтална.

1.4.Төрийн үйлчилгээний албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийг баримтална.

1.5.Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хууль, энэхүү журам, тэдгээрт нийцүүлсэн хөдөлмөрийн дотоод журмыг баримтлан дараах зөрчил гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна.

1.5.1.Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг үүргийг зөрчсөн;

1.5.2.Төрийн албаны тухай хуульд заасан хориглох зүйлийг зөрчсөн;

1.5.3.хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан албан үүргээ биелүүлээгүй.

1.6.Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахдаа дараах зарчмыг баримтална.

1.6.1.хууль зүйн үндэслэлтэй, зөрчил тогтоогдсон байх;

1.6.2.шударга, ил тод байх;

1.6.3.сахилгын шийтгэл нь гаргасан зөрчлийн шинж байдалд тохирсон байх;

1.6.4.сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахгүй байх.

1.7.Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг заавал шалган тогтоож, төрийн албан хаагчид өөрт нь мэдэгдэж, тайлбар, санал гаргах боломжоор хангасан байна.

Хоёр. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг шалган тогтоох

2.1.Сахилгын зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн талаар

гомдол гаргасан, мэдээлсэн, эсхүл холбогдох баримтыг илрүүлснээр зөрчлийг шалгана.

2.2.Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах эсэх үндэслэлийг тухайн байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгж, нэгж байхгүй тохиолдолд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гурваас доошгүй албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг /цаашид “шалгагч” гэх/ байгуулж, шалган тогтооно. Ажлын хэсэгт хууль, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчийг оролцуулж болно.

2.3.Сахилгын шийтгэл ногдуулах эсэх үндэслэлийг 14 хоногт багтаан шалгана. Зайлшгүй нэмэлт ажиллагаа хийх, нотлох баримт цуглуулах шаардлагатай тохиолдолд шалгах хугацааг томилох эрх бүхий албан тушаалтан 10 хүртэл хоногоор сунгаж болно.

2.4.Шалгагч нь энэ журмын 2.1-д заасан гомдол, мэдээлэл, баримтын дагуу дараах ажиллагааг хийнэ:

2.4.1.гомдол гаргагчаас тайлбар, тодруулга авах;

2.4.2.гомдол, мэдээлэлд холбогдох албан хаагчаас бичгээр тайлбар авах;

2.4.3.шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх;

2.4.4.гаргасан зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг тогтоох;

2.4.5.баримтад дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргах.

2.5.Шалгагч нь мэдээлэл, нотлох баримтад үндэслэн сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын зөрчил гаргаагүй дүгнэлтийн аль нэгийг энэ журмын 2.3-т заасан хугацаанд гаргаж, гомдол, мэдээлэлд холбогдох албан хаагчид танилцуулж, тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд талууд гарын үсэг зурна.

2.6.Гомдол, мэдээлэлд холбогдох албан хаагч дүгнэлт, нотлох баримттай танилцаж, 5 хүртэлх өдрийн дотор нэмэлт тайлбар гаргах эрхтэй.

2.7.Шалгагч нь энэ журмын 2.3-т заасан хугацаанд дүгнэлтийг нотлох баримт, тэмдэглэлийн хамт томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.

Гурав. Сахилгын шийтгэл ногдуулах

3.1.Байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан /цаашид “албан тушаалтан” гэх/ шалгагчийн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрийг гаргана.

3.1.1.Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах;

3.1.2.сахилгын шийтгэл ногдуулахаас татгалзах;

3.1.3.нэмэлт шалгалт хийлгэх шаардлагатай гэж үзвэл үндэслэлийг тодорхой зааж, дүгнэлтийг шалгагчид буцаах.

3.2.Томилох эрх бүхий албан тушаалтан нь гомдол, мэдээлэлд холбогдох албан хаагчийн харьяалах нэгжийн удирдлагад шалгагчийн дүгнэлтийг танилцуулж, зөрчлийн шинж байдалд нь нийцсэн сахилгын шийтгэл ногдуулна.

3.3.Сахилгын шийтгэл ногдуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж болно:

3.3.1.зөрчил гаргасан нөхцөл байдал, үр дагавар;

3.3.2.зөрчлийн санаатай болон болгоомжгүй хэлбэр;

3.3.3.албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүрэг болон түүний үйлдэл, эс үйлдэхүйн хоорондын хамаарал;

3.3.4.анх буюу давтан үйлдсэн эсэх;

3.3.5.зөрчлөө сайн дураар хүлээн зөвшөөрч, дүгнэлт хийж, ухамсарласан байдал;

3.3.6.зөрчлийн улмаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авсан эсэх;

3.3.7.бусад албан хаагч, байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндэд болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл;

3.3.8.өөртөө болон бусдад давуу байдал бий болгох зорилгоор зөрчил гаргасан;

3.3.9.хэд хэдэн сахилгын зөрчил гаргасан.

3.4.Сахилгын зөрчил анх удаа гаргасан, сайн дураар хүлээн зөвшөөрсөн, хүнд үр дагаварт хүргээгүй, хохирол учруулаагүй, зөрчлийн үр дагаврыг арилгасан зэрэг байдлыг харгалзан үзэж зөрчил гаргасан албан хаагчид сануулах шийтгэл ногдуулах нь илүү үр дүнтэй гэж үзсэн тохиолдолд албан хаагчид өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулж болно.

3.4.1.албан хаагчид өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах сахилгын шийтгэлийг ногдуулахдаа томилох эрх бүхий албан тушаалтан нь байгууллагын хууль, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн удирдлага, эсхүл албан хаагчийг байлцуулж тэмдэглэл хөтлөн, шийдвэрийг танилцуулна.

3.4.2.албан хаагчид нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулахдаа хамт олны хурал, эсхүл байгууллагын дотоод албан ажлын цахим сүлжээгээр зарлан танилцуулна.

3.5.Албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад сахилгын зөрчил дахин гаргасан, эсхүл зөрчлийн шинж байдал нь төрийн албанаас халах үндэслэлгүй байвал

албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулж болно.

3.6.Энэ журмын 3.6-д заасан сахилгын шийтгэл ногдуулах тухай шийдвэрт цалин бууруулах хувь хэмжээ, хугацааг тодорхой тусгаж, санхүүгийн асуудал хариуцсан нэгжид шийдвэр гарснаас хойш ажлын 2 өдөрт багтаан өгнө.

3.7.Албан хаагч сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 3 ба түүнээс дээш удаа сахилгын зөрчил давтан гаргаж, шийтгэл хүлээсэн, эсхүл зөрчлийн шинж байдал нь тухайн албан хаагчийг төрийн албанд цаашид ажиллуулах боломжгүй гэж үзэх үндэслэлтэй бол төрийн албанаас халах шийтгэлийг ногдуулна.

Тайлбар: Төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй гэдгийг албан хаагчид хамгийн сүүлд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй байх.

3.8.Төрийн албаны тухай хуульд тусгайлан заасан зөрчлийг гаргасан төрийн албан хаагчид төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

3.9.Албан тушаалтан нь албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг 2 хувь үйлдэж, шийдвэрийн нэг хувийг албан хаагчид гардуулж, хоёр дахь хувийг хувийн хэрэгт нь хадгална.

3.10.Тухайн төрийн байгууллага нь сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэж, оруулна.

3.11.Албан хаагч эмнэлгийн магадлагаатай, ээлжийн амралттай, хувийн чөлөөтэй байсан, түүнчлэн зөрчил гаргасан эсэхийг шалгасан хугацааг сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сарын хугацаанд оруулан тооцохгүй.

Дөрөв.Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрт гомдол гаргах, хянан шийдвэрлэх

4.1.Албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн шийдвэрийг мэдсэн буюу хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүхэд гомдлоо бичгээр гаргана.

4.2.Төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн байгууллага нь “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд нэмэлтээр бүртгэнэ.

4.3.Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад тухайн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах,

зэрэг дэв шинээр болон нэмэгдүүлэн олгохыг хориглоно.

4.4. Сахилгын зөрчил гаргаж, шийтгэл хүлээсэн албан хаагч байгууллага, хувь хүнд учруулсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 7639 дүгээрт бүртгэв

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/111

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаалаар баталсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын дарга нарт, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүлийн бодлогын газар, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/150 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т.АУБАКИР

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны
6 дугаар сарын 11-ний өдрийн А/111 дүгээр тушаалын хавсралт*

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч (цаашид “хохирогч” гэх)-ийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийг нэг хүнд ногдох хувьсах зардлаар тооцоход энэхүү журмыг баримтална.

1.2.Энэхүү журам нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасны дагуу Нэг цэгийн үйлчилгээний төвд хамаарна.

1.3.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хоол хүнсний болон үйлчилгээ үзүүлсэн зардлыг тооцохдоо “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, норматив”-ыг баримтлах бөгөөд тусгагдаагүй бусад зардлыг тооцоход энэ журмыг баримтална.

1.4.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байна. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн хугацааг 1 удаа 30 хоногоор сунгаж болно.

Хоёр.Нэг хүнд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн

2.1.Нэг хүнд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд дараах зардлыг хамааруулна.

2.1.1.Хоол хүнсний зардал;

2.1.2.Хувийн ариун цэврийн хэрэглэлийн зардал;

2.1.3.Хувцас, хэрэглэлийн зардал;

2.1.4.Хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардал;

2.1.5.Гэнэтийн болон урьдчилан тооцоолоогүй зардал.

2.2.Нэг хүнд ногдох хувьсах зардлыг дараах томьёогоор тооцно:

$$НХЗ=ХХЗ+АЦХЗ+ХувЗ+ҮЗ+ГЗ$$

2.2.1.НХЗ - нэг хүнд ногдох хувьсах зардал

2.2.2.ХХЗ - хоол хүнсний зардал

2.2.3.АЦХЗ - ариун цэврийн хэрэглэлийн зардал

2.2.4.ХувЗ - хувцас хэрэглэлийн зардал

2.2.5.ҮЗ - үйлчилгээний зардал

2.2.6.ГЗ - гэнэтийн зардал

Гурав.Зардлыг тооцох аргачлал

3.1.Хоол хүнсний зардлыг тооцохдоо нийгмийн халамжийн

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан «Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив»-ыг баримтална. Өдөрт 3 үндсэн хоол, өглөөний цайгаар тооцно.

3.2.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан хохирогчид хувийн ариун цэврийн хэрэглэлийн багцыг нэг удаа олгоно. Багцад шүдний оо, сойз, алчуур, саван, шампунь, ариун цэврийн цаас, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэл орно. Багцын үнийг тооцоход “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа насанд хүрэгсдийн хувцас, ариун цэврийн хэрэглэлийн зардлын норматив”-аар тооцно. Хугацаа сунгагдсан тохиолдолд багцыг дахин нэг удаа олгож болно.

3.3.Хохирогчид зайлшгүй хэрэгцээтэй гутал, гадуур болон дотуур хувцсыг “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа насанд хүрэгсдийн хувцас, ариун цэврийн хэрэглэлийн зардлын норматив”-ыг баримтлан нэг удаа олгоно.

3.4.Хохирогчид үзүүлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна.

- 3.4.1.эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
- 3.4.2.сэтгэл зүйн үйлчилгээ;
- 3.4.3.нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 3.4.4.хүүхэд хамгааллын үйлчилгээ;
- 3.4.5.эрх зүйн тусалцаа.

3.5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг тооцохдоо Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үйлчилгээний үнэ хөлс”-ийг баримтална.

3.6.Сэтгэл зүйн үйлчилгээний зардлыг ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ, үнэлгээ, сургалтын хэрэглэгдэхүүн, нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг хамруулан тооцох бөгөөд өмнөх онд зарцуулсан нийт зардлыг сургалтад хамруулсан хүний тоонд хувааж дундаж зардлаар тооцно.

3.7.Нийгмийн халамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1-д заасан үйлчилгээнд холбон зуучилж үзүүлнэ.

3.8.Хүүхэд хамгааллын үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 19.1-д заасны дагуу үзүүлнэ.

3.9.Эрх зүйн тусламж үйлчилгээний зардлыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Хууль зүй дотоод хэргийн сайдын баталсан “Нотариатын үйлчилгээний хөлс, зардал”-ыг баримтална.

3.10.Энэ журмын 3.5, 3.9-д заасан үйлчилгээний зардлыг өмнөх 3 жилийн дундаж хэрэглээний давтамжаар үржүүлж тооцно.

3.11.Дараах үйлчилгээг холбон зуучлах зардлаар тооцно.

3.11.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

3.11.2.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ;

3.11.3.Нийгмийн халамжийн үйлчилгээ;

3.11.4.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үйлчилгээ.

3.12.Холбон зуучлах үйлчилгээний зардалд тээврийн хэрэгслээр үйлчлэх, бичиг хэрэг, харилцаа холбооны зардал хамруулна.

3.12.1.Тээврийн хэрэгслээр үйлчлэх зардлыг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг үндэслэн өмнөх онд тухайн үйлчилгээ үзүүлэхэд зарцуулсан нийт явалт, шатахууны хэрэглээ, холбогдох зардлыг тооцож, нэг үйлчлүүлэгчид ногдох дундаж зардлыг тодорхойлно;

3.12.2.Бичиг хэргийн болон харилцаа холбооны зардлыг “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, норматив”-т заасан жишиг зардлыг үндэслэн тооцно.

3.13.Энэ журмын 3.12-д заасан үйлчилгээ тус бүрийг үйлчилгээ үзүүлсэн давтамжаар үржүүлж гаргана.

3.14.Энэ журмын 2.1.5-д заасан зардлыг тухайн жилийн нэг хүнд ногдох нийт хувьсах зардлын 5 хүртэл хувиар тооцож болно.

Дөрөв.Жилийн нийт зардлын хэмжээг тооцох

4.1.Жилийн нийт хувьсах зардлыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд сүүлийн 36 сарын хугацаанд хамрагдсан хохирогчдын дундаж тоо болон нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээнд үндэслэн тооцно.

4.2.Жилийн төсөв тооцох томьёо $ЖНЗ = ДХТ \times НХЗ$

4.2.1.ЖНЗ - жилийн нийт зардал

4.2.2.ДХТ - дундаж хохирогчийн тоо

4.2.3.НХЗ - нэг хүнд ногдох хувьсах зардал

4.3.Энэ журмын 4.1-д заасан зардлыг Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд заасан өмнөх оны хэрэглээний үнийн өсөлтийн түвшингөөр нэмэгдүүлэн төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагад саналаа хүргүүлнэ.

4.4.Жилийн нийт зардлыг тооцоход ашиглах тоо баримтууд албан ёсны мэдээ, тайлан, статистик болон хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын /HIMS/ цахим системд бүртгэсэн хохирогчдын мэдээлэлд үндэслэсэн байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/174

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төмөр замын тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газар /Х.Итгэлт/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 154 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 6 дугаар
сарын 23-ны өдрийн А/174 дүгээр тушаалын хавсралт*

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журам нь төмөр замын тээврийн байгууллага болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн үйл ажиллагаанд гарсан төмөр замын тээврийн осол, зөрчлийг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн “Зөрчил” нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн ойлголтод хамаарахгүй бөгөөд төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын үйл явдлыг ангилах зориулалттай ойлголт болно.

1.3. Осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны зорилго нь тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг үнэн зөв тогтоох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сайжруулахад оршино.

1.4. Шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд осол, зөрчлийг бүртгэх, тайлан гаргах, дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулна.

1.5. Төмөр замын тээврийн байгууллага болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь энэхүү журмыг мөрдөхөөс гадна өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон осол, зөрчил бүртгэх, шинжлэн шалгах, тайлагнах, урьдчилан сэргийлэх болон аюулгүй байдлыг сайжруулах дотоод журам, зааврыг батлан мөрдөж болно.

1.6. Осол, зөрчил, гаднын нөлөөлөлтэй үйл явдлыг бүрэн, тасралтгүй бүртгэж, тэдгээрийн давтамж, хандлага, уялдаа холбоонд дүн шинжилгээ хийснээр төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох нь шинжлэн шалгах үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙН АНГИЛАЛ

2.1. Төмөр замын тээврийн осол

Дараах үйл явдлын улмаас хүний амь нас хохирсон, хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалтаас хасах,

их засвар хийх хэмжээнд гэмтсэн тохиолдлыг төмөр замын тээврийн осолд тооцно:

2.1.1.Хөдлөх бүрэлдэхүүн өөр хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн

2.1.2.Хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан;

2.1.3.Аюултай ачаа асгарсан - аюултай ачаа тээвэрлэх үед вагон, чингэлэг, сав баглаа боодол, цистерн вагоны сав, арматур, юүлэх төхөөрөмжийн гэмтлийн улмаас аюултай ачаа асгарсан.

2.2.Төмөр замын тээврийн зөрчил

Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдал алдагдсан, осол гарах бодит аюул бий болгосон, эсвэл төмөр замын тээврийн үйл ажиллагаанд саатал, хохирол учруулсан, энэхүү журмын 2.1-д заасан үр дагавар үүсээгүй дараах үйл явдлыг төмөр замын тээврийн зөрчилд тооцно:

2.2.1.Хөдлөх бүрэлдэхүүн өөр хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн - хоорондын зам, өртөө, зөрлөгт галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, зэхэлт, бусад шилжилт хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн өөр хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдөж, хөдлөх бүрэлдэхүүнд урсгал засвар хийх хэмжээнд гэмтэл учирсан;

2.2.2.Хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан - хоорондын зам, өртөө, зөрлөгт галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, зэхэлт, бусад шилжилт хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүний дугуй зам төмрийн толгойноос унаж замаас гарсан;

2.2.3.Хөдлөх бүрэлдэхүүн гаднын объект мөргөсөн - хөдлөх бүрэлдэхүүн механизм, тоног төхөөрөмж, гаднын объектой мөргөлдөж, хөдлөх бүрэлдэхүүн эсхүл суурь бүтцэд урсгал засвар хийх хэмжээнд гэмтэл учирсан;

2.2.4.Хөдлөх бүрэлдэхүүн өөрөө хөдөлсөн - хөдлөх бүрэлдэхүүн өртөөний замаас өөрөө хөдөлж, галт тэрэг хүлээн авах, явуулах замнал, эсхүл хоорондын зам руу орсон;

2.2.5.Галт тэргийг эзэлгээтэй замд хүлээн авсан - урих дохио болон журмаар зөвшөөрснөөс бусад үед галт тэргийг хөдлөх бүрэлдэхүүнээр эзлэгдсэн хүлээн авах замд оруулсан;

2.2.6.Галт тэргийг эзэлгээтэй хоорондын замд явуулсан хагас - автомат хориглолын үед галт тэрэг, эсхүл хөдлөх бүрэлдэхүүнээр эзлэгдсэн хоорондын зам руу галт тэрэг явуулах зөвшөөрөл олгож, гаргах дохио /дохиогүй бол хязгаарын шон/-г хөдлөх бүрэлдэхүүний аль нэг хэсгээр өнгөрсөн;

2.2.7.Бэлэн бус замналаар галт тэрэг хүлээн авсан, явуулсан - галт тэрэг хүлээн авах, явуулах замнал бэлтгэгдээгүй байхад оруулах, явуулах зөвшөөрөл олгосон;

2.2.8.Хөдлөх бүрэлдэхүүн хориглосон дохио өнгөрсөн - галт тэрэг, зүтгүүр, замаас авагддаггүй нэгжийг өртөөнд хүлээн авах, явуулах болон сэлгээний хөдөлгөөний үед хориглосон заалттай гэрлэн дохио, зөөврийн зогсох дохио, эсхүл хязгаарын шонг өнгөрсөн;

2.2.9.Хөдлөх бүрэлдэхүүний дор сум шилжсэн-төвлөрүүлэлтийн системийн алдаа, хөдлөх бүрэлдэхүүн сумын секцийг бүрэн чөлөөлөөгүй байхад сумыг албадан шилжүүлсэн, зам төмрийн хэлхээний мэдрэмж алдагдсанаас хөдлөх бүрэлдэхүүн дор сум шилжиж, тухайн замналаас өөр замнал бэлтгэгдсэн;

2.2.10.Дохио буруу дохиолсон гэрлэн дохионы хориглосон заалт зөвшөөрсөн заалт руу, эсхүл хурд бууруулан явахыг шаардсан заалт илүү зөвшөөрсөн заалт руу хуурамчаар шилжсэн;

2.2.11.Галт тэрэгний авто угсраа өөрөө салсан, тасарсан хөдлөх бүрэлдэхүүний авто угсрааны холбоос өөрөө салсан, авто угсрааны эд анги тасарсан;

2.2.12.Хөдлөх бүрэлдэхүүн доор зам төмөр хугарсан-хөдлөх бүрэлдэхүүний ачаалал авч байсан зам төмөр хугарсан;

2.2.13.Хөдлөх бүрэлдэхүүний эд анги хугарсан-хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйн гол, голын хүзүү, дугуй, хажуу арал, нумын дээд дам нуруу, ноён нуруу хугарсан, тасарсан;

2.2.14.Хөдлөх бүрэлдэхүүний эд анги зам дээр унасан-хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний явцад түүний эд анги зам дээр унаж, хөдөлгөөнийг үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсхүл төмөр замын төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд саад учруулсан;

2.2.15.Ачаа зам дээр унасан, шилжсэн-аяллын замд шингэн болон нурмаг ачаанаас бусад ачаа, чингэлэг зам дээр унасан, эсхүл бэхэлгээ алдагдсаны улмаас ачаа байрнаасаа шилжиж тогтоосон ачилтын овроос хэтэрсэн;

2.2.16.Зорчигчийн галт тэрэгнээс вагон салгасан-вагоны гэмтлийн улмаас аяллын замд зорчигчийн галт тэрэгнээс вагон салгасан;

2.2.17.Төгсгөлийн кран хаалттай галт тэрэг явуулсан-галт тэрэгний хөдлөх бүрэлдэхүүн хооронд төгсгөлийн кран хаалттай байхад галт тэргийг хоорондын замд явуулсан;

2.2.18.Зорчигчийн галт тэрэгний аялалыг цуцалсан, зорчигч буулгасан - хөдлөх бүрэлдэхүүний техникийн гэмтэл, чанаргүй засвар үйлчилгээ, зүтгүүрийн бригадын буруу үйл ажиллагааны улмаас зорчигчийн галт тэрэгний аялалыг цуцалсан, эсхүл завсрын өртөөнд зорчигч буулгасан;

2.2.19.Гүүшин халсны улмаас вагон салгасан-гүүшин халсны улмаас ачааны галт тэрэгнээс вагон хоорондын зам, эсхүл завсрын

өртөөнд салгасан;

2.2.20. Ачилтын техникийн нөхцөл зөрчигдсөний улмаас вагон салгасан - ачаа, тээш, ачаан тээш ачих техникийн нөхцөл зөрчигдсөний улмаас ачаа зам дээр унаж болзошгүй, ачилтын овроос хэтэрсэн тул вагон завсрын өртөөнд салгасан;

2.2.21. Зорчигчийн галт тэрэгний зүтгүүр гэмтсэн - зорчигчийн галт тэрэгний зүтгүүрт техникийн гэмтэл гарч хоорондын зам эсвэл завсрын өртөөнд туслах зүтгүүрээр хөдөлгөөнийг үргэлжлүүлсэн, эсхүл зүтгүүр сольсон.

2.3. Төмөр замын тээврийн гаднын нөлөөлөлтэй үйл явдал

Байгалийн аюулт үзэгдэл, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл болон төмөр замын байгууллагын үйл ажиллагаанаас үл хамаарах бусад хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн осол, зөрчлийг төмөр замын тээврийн гаднын нөлөөлөлтэй үйл явдалд тооцно:

2.3.1. Байгалийн аюулт болон гадн болон гаднын нөлөөллийн улмаас төмөр замын тээвэрлэлт, суурь бүтэц, хөдлөх, бүрэлдэхүүний хэвийн үйл ажиллагаа алдагдаж осол, зөрчил үүссэн;

2.3.2. Төмөр замын гарам дээр авто замын хөдөлгөөнд оролцогчтой холбоотойгоор хөдлөх бүрэлдэхүүн тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөн;

2.3.3. Төмөр замын хамгаалалтын бүсэд хүн, амьтан нэвтэрснээс галт тэрэгний хөдөлгөөн саатсан.

2.4. Төмөр замын тээврийн байгууллага нь үйл ажиллагааны онцлогоос хамааран хөдөлгөөний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй, галт тэрэгний хөдөлгөөн саатсан, зурмагийн тасалдал үүссэн бусад үйл явдлыг дотоод журмаар дутагдалд хамруулан бүртгэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ

3.1. Осол, зөрчлийг шуурхай мэдээлэх

3.1.1. Төмөр замын тээврийн байгууллага болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь осол, зөрчил гарсан тухай мэдээллийг харилцаа холбооны хэрэгслээр нэн даруй, гэхдээ 1 цагаас хэтрэхгүй хугацаанд дараах байгууллагад мэдэгдэнэ:

- төрийн захиргааны төв байгууллага;
- төрийн захиргааны байгууллага, түүний төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, холбогдох улсын байцаагч;

Мөн осол, зөрчлийн нөхцөл байдлаас хамааран шаардлагатай тохиолдолд дараах байгууллагад шуурхай мэдэгдэнэ:

- онцгой байдлын байгууллага;
- эмнэлгийн байгууллага;
- цагдаагийн байгууллага;
- орон нутгийн удирдах байгууллага;
- тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч.

3.1.2.Харилцаа холбооны хэрэгслээр шуурхай мэдээлэл өгөхдөө осол, зөрчил гарсан газар, огноо, цаг, нөхцөл байдал, урьдчилсан хохирлын мэдээлэл, холбогдох байгууллага, этгээдийн нэр, мэдээлэл өгсөн этгээдийн нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаарыг мэдэгдэнэ.

3.2.Бичмэл мэдээлэл

3.2.1.Шуурхай мэдээллийг өгснөөс хойш 12 цагийн дотор энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу бичмэл мэдээллийг үйлдэж, энэ журмын 3.1.1-д заасан байгууллага, албан тушаалтан болон холбогдох этгээдэд хүргүүлнэ.

3.3.Осол, зөрчлийн нэгдсэн мэдээлэл

3.3.1.Төмөр замын, тээврийн байгууллага болон үйлдвэрлэлийн тухайн зориулалттай төмөр зам, салбар зам хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь сард гарсан осол, зөрчлийн нэгдсэн мэдээллийг дараагийн сарын 10-ны өдрийн дотор төрийн захиргааны байрууллагад хүргүүлнэ.

3.3.2.Төрийн захиргааны байгууллага нь тухайн сард гарсан осол, зөрчлийн нэгдсэн мэдээллийг нэгтгэн, дараагийн сарын 20-ны өдрийн дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөх

3.4.1.Осол, зөрчлийн талаар олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгөх мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан өгнө.

3.4.2.Шинжлэн шалгах ажиллагаа дуусаагүй байхад осол, зөрчлийн шалтгаан, буруутай этгээдийн талаар урьдчилсан дүгнэлт бүхий мэдээлэл, ярилцлага өгөхийг хориглоно.

3.4.3.Олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөхдөө төрийн, албаны, байгууллагын болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

4.1.Осол, зөрчлийг шинжлэн шалгах

4.1.1.Шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан байж, осол, зөрчил гарсан шалтгаан, нөхцөлийг үнэн зөв тогтоох, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

4.1.2.Осол, зөрчлийг шинжлэн шалгаж тайлан гаргах бөгөөд тайланд тухайн үйл явдлын нөхцөл байдал, шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл, цаашид авах арга хэмжээг тусгана.

4.1.3.Төрийн захиргааны төв байгууллага нь осол, зөрчлийг шинжлэн шалгах болон тайлан боловсруулахтай холбоотой аргачлал баталж, мөрдүүлж болно.

4.1.4.Зөрчлийн тайлан, холбогдох баримт материалыг хянаж шаардлагатай гэж үзвэл шинжээчийн дүгнэлт, улсын ахлах байцаагчийн шийдвэрээр тухайн үйл явдлыг дахин ангилж, нэмэлт болон дахин шинжлэн шалгаж болно.

4.2.Ослыг шинжлэн шалгах

4.2.1.Төмөр замын тээврийн ослыг төрийн захиргааны төв байгууллагаас томилсон баг шинжлэн шалгана. Осол шинжлэн шалгах чиг үүрэг бүхий орон тооны бус байнгын баг ажиллуулж болно.

4.2.2.Шинжлэн шалгах баг нь төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга, осол шинжлэн шалгах шинжээч, мэргэжилтэн, улсын ахлах байцаагч, улсын байцаагчаас бүрдэнэ. Шаардлагатай тохиолдолд осолтой холбоотой байгууллагын албан тушаалтан, мэргэжилтэн, хууль ёсны төлөөлөгч болон хараат бус шинжээчийг оролцуулж болно.

4.2.3.Шинжлэн шалгах багийн шинжээч улсын байцаагч нь хууль тогтоомж болон энэ журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Багт оролцож буй бусад мэргэжилтэн, хараат бус шинжээч нь өөрийн мэргэжлийн чиглэлээр дүгнэлт, зөвлөгөө өгч ажиллана.

4.2.4.Осол шинжлэн шалгах шинжээч нь шинжлэн шалгах ажиллагааны явцад:

- осол болсон газар болон холбогдох объектод саадгүй нэвтрэх;
- холбогдох этгээдээс тайлбар, мэдээлэл авах;
- баримт бичиг, техник хэрэгслийн мэдээлэлтэй танилцах, шалгах;
- хөдөлгөөний бүртгэлийн төхөөрөмжийн мэдээллийг шалгах;
- шаардлагатай бол шинжилгээ, туршилт хийлгэх;
- осол шинжлэн шалгах ажиллагааг хараат бус, шударга, мэргэжлийн түвшинд явуулах;
- ослын шалтгаан, нөхцөлийг нотлох баримтад үндэслэн үнэн зөв тогтоох;
- цуглуулсан баримт, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалтыг хангах,
- шинжлэн шалгах ажиллагааны явцад олж авсан нууцад хамаарах болон хувь хүний мэдээллийг задруулахгүй байх.

4.2.5.Төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх бөгөөд шинжлэн шалгах ажиллагааны явцад шинжээчтэй хамтран ажиллаж, нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу хамгаална.

4.2.6.Осол шинжлэн шалгах явцад тухайн үйл явдалд хууль тогтоомж зөрчсөн шинж илэрсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуульд заасан журмын дагуу зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулна.

4.2.7.Осол шинжлэн шалгах явцад гэмт хэргийн шинж илэрсэн тохиолдолд холбогдох материалыг эрх бүхий мөрдөн шалгах байгууллагад шилжүүлнэ.

4.3.Зөрчлийг шинжлэн шалгах

4.3.1.Энэхүү журмын 2.2-т заасан зөрчлийг төмөр замын тээврийн байгууллага болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч дотоод журмын дагуу шинжлэн шалгаж, холбогдох дүгнэлт, тайлан гаргана.

4.4.Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн үүрэг

4.4.1.Осол, зөрчил гарсан тохиолдолд төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь шуурхай арга хэмжээ авч, дотоод шалгалтыг зохион байгуулах;

4.4.2.Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж, анхан шатны тусламж үзүүлэх;

4.4.3.Энэ журмын 3.1, 3.2-т заасны дагуу шуурхай болон бичмэл мэдээллийг хүргүүлэх;

4.4.4.Осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтооход ашиглагдаж болох баримт бичиг, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, бүрдэл хэсэг, эд зүйлийг хэвээр нь хадгалж, хамгаалах, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.4.5.Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай бол шинжээч, улсын байцаагчид мэдэгдэж осол, зөрчлийн улмаас эвдэрч гэмтсэн хөдлөх бүрэлдэхүүн, барилга, байгууламж, эд зүйлсийг эвдэх, задлах, нээх, замаас зайлуулах, ослын газар болон аюултай бүсийг хамгаалалтад авах, татан буулгах, аюултай ачааны хор хөнөөлийг саармагжуулах зэрэг шуурхай арга хэмжээ авах;

4.4.6.Осол, зөрчил гарсан газарт шинжээч, улсын байцаагчийг саадгүй нэвтрүүлэх, холбогдох баримт бичиг буюу илчит тэрэгний хурд хэмжигч, мэдээлэл бүртгэгчийн мэдээлэл /тууз/, бусад цуглуулсан нотлох баримтыг шинжээч, улсын байцаагч болон дотоод шалгалтын

багт гаргаж өгөх;

4.4.7.Төмөр замын тээврийн байгууллага нь осол, зөрчил гарсан газарт ажиллах шинжлэн шалгах баг, шинжээч, улсын байцаагчийг шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбооны болон тээврийн хэрэгслээр хангах;

4.4.8.Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь осол болсон газрын үзлэг дууссаны дараа цагдаагийн мөрдөгч эсвэл улсын ахлах байцаагчийн зөвшөөрлөөр суурь бүтэц болон хөдөлгөөн сэргээх ажлыг эхлүүлнэ.

4.5.Шинжлэн шалгах ажиллагаа

4.5.1.Осол, зөрчил гарсан үед төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь осол, зөрчил гарсан газарт шинжээч эсвэл улсын байцаагч хүрэлцэн ирэхээс өмнө тэдэнд мэдэгдэж, осол, зөрчлийн нөхцөл байдлаас хамааран дараах ажил, үүргийг гүйцэтгэнэ:

4.5.1.1.Хурд хэмжигчийн тууз, галт тэрэгний хөдөлгөөний мэдээллийг бүртгэх төхөөрөмж /мэдээлэл хадгалагч/, галт тэрэгний биечилсэн хуудас, тоормосны хангамжийн мэдээлэл, хурд хязгаарласан тухай анхаарамж, зүтгүүрийн ширээний журнал, бусад баримт бичиг, бүртгэлийн мэдээллийг хадгалж, шаардлагатай бол хуулбарлан авах;

4.5.1.2.Осол, зөрчил гарсан газар, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг хийсэн тухай акт үйлдэх;

4.5.1.3.Суурь бүтэц, замын байгууламж болон хөдлөх бүрэлдэхүүний гэмтлийг тодорхойлох;

4.5.1.4.Осол, зөрчлийн нөхцөл байдал, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний байдал, эвдрэл, гэмтэл, гаднын болон ойр орчимд байгаа эд зүйлсийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.5.1.5.Осол, зөрчилд холбоотой ажилтан, гэрчээс бичгээр тодорхойлолт авч, шаардлагатай бол дуу, дүрс бичлэгээр баримтжуулах;

4.5.1.6.Осол, зөрчил болсныг баримтжуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах суурь бүтцийн тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил, замаас гарсан эхлэл, төгсгөлийн ул мөрийг заасан бүдүүвч зураг гаргах;

4.5.1.7.Осол, зөрчил гарах үеийн цаг агаарын байдлын талаар тэмдэглэл хийж, шаардлагатай бол холбогдох баримтыг авах;

4.5.2.Шинжилгээ, туршилт хийх зардлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

4.5.3.Энэхүү журмын 2.1, 2.2 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн үед хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд үзлэг

хийх болон дахин ашиглах боломжгүй, их засварт оруулах хэмжээний эвдрэлтэй эсэх акт гаргахад шинжээч, төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийг оролцуулна.

4.5.4.Ослыг шинжлэн шалгах баг, шинжээч нь ослын шалтгаан, нөхцөлийг тогтоож, тайланг аль болох богино хугацаанд боловсруулна. Тайлангийн төслийг осол, зөрчилд оролцогч байгууллагад хүргүүлж, баримт мэдээллийн зөрүү, техникийн алдаа, үндэслэл бүхий тайлбартай холбоотой саналыг төслийг хүлээн авснаас хойш ажлын 7 / долоо/ өдрийн дотор бичгээр ирүүлэхийг мэдэгдэнэ. Ирүүлсэн саналыг шинжлэн шалгах баг хянаж үзээд, үндэслэлтэй гэж үзсэн саналыг тусгана. Үндэслэлгүй гэж үзсэн саналыг тайланд хавсаргана. Тогтоосон хугацаанд санал ирүүлээгүй бол тайлангийн төслийг зөвшөөрсөнд тооцож, эцсийн тайланг баталгаажуулна.

4.5.5.Шинжлэн шалгах багийн шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Санал нийлээгүй багийн гишүүн өөрийн тусгай саналыг тайланд хавсаргана.

4.5.6.Осол, зөрчлийн шалтгааныг тогтоохдоо нотлох баримт, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн тэдгээрийн эд анги, техник, тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээхгүй, үрэгдүүлэхгүй, сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох шинжээч, улсын байцаагчийн зөвшөөрлөөр мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгүүлнэ.

4.5.7.Осол, зөрчлийн тайланд дараах баримт, мэдээллийг хавсаргана:

- гэмтсэн, хохирсон хүмүүсийн мэдээлэл, холбогдох шинжээчийн дүгнэлт;
- хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцийн гэмтэл, техникийн нөхцөл байдал, ашиглалтад цаашид ашиглах боломж, их засвар хийх эсэхийг тодорхойлсон акт, дүгнэлт;
- хохирлын хэмжээг тодорхойлсон баримт, тооцоо;
- шаардлагатай тохиолдолд хийгдсэн шалган турших ажиллагааны акт, дүгнэлт;
- галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн хуулбар болон хөдөлгөөний бүртгэлийн мэдээлэл;
- суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, арчлалт, техникийн байдалтай холбоотой баримт бичиг, бүртгэл, тайлангийн хуулбар;
- осол, зөрчил болсон газрын болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, бүдүүвч зураг,

- тухайн үеийн цаг агаарын нөхцөлийн талаарх холбогдох байгууллагын мэдээлэл;
- осол, зөрчилд холбогдох ажилтны техникийн мэдлэг, мэргэжлийн бэлтгэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эмнэлгийн үзлэг, ажил, амралтын горимтой холбоотой баримт;
- шаардлагатай бусад баримт, мэдээлэл.

4.6. Нууцлал, мэдээллийн хамгаалалт

4.6.1. Осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны явцад олж авсан дараах мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй;

4.6.1.1. Холбогдогч, гэрч болон бусад этгээдийн тайлбар, мэдүүлэг, хувь мэдээлэл;

4.6.1.2. Шинжлэн шалгах ажиллагааны явцад цуглуулсан акт, фото зураг, дуу, дүрс бичлэг, бүдүүвч зураг, хөдөлгөөний бүртгэлийн төхөөрөмж болон техникийн мэдээлэл;

4.6.1.3. Осол, зөрчилд өртсөн, хохирсон хүний эрүүл мэндийн болон бусад хувийн мэдээлэл;

4.6.1.4. Шинжлэн шалгах ажиллагааны явцад боловсруулсан санал, дүгнэлт, тайлан болон тэдгээртэй холбоотой дотоод мэдээлэл.

4.7. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

4.7.1. Осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шинжээчийн дүгнэлт, саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага зөвлөмж гаргаж, шаардлагатай тохиолдолд сайдын албан даалгавар хүргүүлнэ.

4.7.2. Төрийн захиргааны байгууллага болон төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлага, албан даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавина.

4.7.3. Төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ БҮРТГЭХ

5.1. Төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан ослын ангиллыг эцэслэн тогтоож, бүртгэнэ.

5.2. Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.2-т заасан зөрчлийн ангиллыг эцэслэн тогтоож, бүртгэнэ.

5.3. Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь өөрийн байгууллагад гарсан осол, зөрчлийг

бүртгэж, холбогдох баримт материалыг холбогдох хууль тогтоомж болон архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хадгална.

5.4.Төмөр замын тээврийн гаднын нөлөөлөлтэй үйл явдлыг тухайн осол, зөрчлийн бүртгэлд тусад нь ангилан бүртгэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

6.1.Осол, зөрчлийн шинжлэн шалгасан дүнгийн талаарх товч мэдээллийг ил тод байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллага олон нийтэд мэдээлж болно.

Нийтэд мэдээлэхдээ дараах мэдээллийг тусгана

- осол, зөрчил гарсан огноо, газар;
- осол, зөрчлийн төрөл, ангилал;
- үр дагаврын ерөнхий мэдээлэл;
- урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ.

Нийтэд мэдээлэхдээ дараах мэдээллийг задруулахыг хориглоно:

- хувь хүний нууц, хувийн мэдээлэл;
- шинжлэн шалгах ажиллагаанд саад учруулах мэдээлэл;
- улсын болон байгууллагын нууцад хамаарах мэдээлэл.

6.2.Ноцтой мэдээлэл. үр дагавартай ослын талаарх мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн байдлаар нийтэд мэдээлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1.Энэхүү журмын хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нь өөр өөрийн бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хяналт тавьж, биелэлтийг хангуулна.

7.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.3.Осол, зөрчилтэй холбоотойгоор худал мэдүүлэг өгөх, баримт бичиг, нотлох баримтыг нуун дарагдуулах, устгах, гэмт хэрэг нуун далдлах үйлдэл гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*Зам, тээврийн сайдын 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн
А/174 дүгээр тушаалын “Төмөр замын тээврийн осол, зөрчлийг
шинжлэн шалгах журам”-ын хавсралт*

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ШУУРХАЙ БИЧМЭЛ МЭДЭЭЛЭЛ

- 1.Осол, зөрчил гарсан газар /нийслэл, аймаг, сум, баг, хороо, өртөө, хоорондын зам, км, зуут/:
- 2.Осол, зөрчил гарсан огноо, цаг, минут:
- 3.Осол, зөрчилтэй холбоотой төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, салбар зам, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч:
- 4.Хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол:
- 5.Осол, зөрчилд өртсөн объект /суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, ачаа, бусад хөрөнгө/:
- 6.Осол, зөрчлийн улмаас төмөр замын тээврийн бус этгээдийн эд хөрөнгө, үйл ажиллагаанд учирсан хохирол:
- 7.Осол, зөрчлийн газарт ажиллаж байгаа холбогдох албан тушаалтны нэр, утасны дугаар:
- 8.Хэргийн газарт үзлэг хийж байгаа цагдаагийн байгууллагын албан хаагчийн нэр, утасны дугаар:
- 9.Осол, зөрчлийн фото зураг, дүрс бичлэг / шаардлагатай бол хавсаргана/:

Шуурхай мэдээлэл өгсөн:

/байгууллага, ажилтны овог нэр, гарын үсэг, утасны дугаар,
цахим шуудангийн хаяг/

... оны... дугаар сарын ...-ны өдөр
... цаг ... минут

Анхаарах нь:

1. Асуултад аль болох дэлгэрэнгүй хариулж, товчилсон үг хэрэглэхгүй байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар А/215

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Б.Янжмаа)-д үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/340 дүгээр, “Журам шинэчлэн батлах тухай” 2026 оны А/79 дүгээр тушаалууд тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Э.БАТШУГАР

*Эрүүл мэндийн сайдын 2026 оны 6 дугаар
сарын 29-ний өдрийн А/215 дугаар тушаалын хавсралт*

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14.1-д заасны дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Энэхүү журмын зорилго нь ажил, хөдөлмөртэй холбоотой эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг тодорхойлох, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдахаас болон ажилтны эрүүл мэндийн нөхцөл байдлаас шалтгаалан үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

1.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага энэхүү журмыг хэрэгжүүлэхэд ажил олгогч, эрүүл мэндийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.4.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ энэхүү журмаас гадна үндэсний эсхүл олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эмнэлзүйн удирдамж, мэргэжлийн аргачлал, стандартыг мөрдөж ажиллана.

Хоёр. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт

2.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны эрсдэлтэй нөхцөлд ажилладаг ажилтны эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг хэрэгжүүлнэ.

2.2.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт нь байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд ажлын байран дахь аюулыг арилгах, бууруулах анхдагч урьдчилан сэргийлэлтийг орлохгүй.

2.3.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт дараах үе шатаар хэрэгжинэ:

2.3.1.хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтад хамруулах шаардлагатай үйлдвэрлэлийн осол, хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлтэй ажил, мэргэжил /цаашид "эрсдэлтэй ажил, мэргэжил"

гэнэ/-ийн жагсаалтыг ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшинд үндэслэн тодорхойлох;

2.3.2.эрсдэлтэй ажил, мэргэжилд ажиллах ажилтанд тавигдах эрүүл мэндийн үзүүлэлтийн лавлагаа /цаашид “*эрүүл мэндийн үзүүлэлтийн лавлагаа*”/-г ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны эрсдэл, ажил мэргэжлийн онцлогоос хамааран энэ журмын хавсралт 3-т заасан зөвлөмжийн дагуу тодорхойлох эсвэл зөвшөөрөгдсөн эмнэл зүйн удирдамж, мэргэжлийн аргачлалыг ашиглах;

2.3.3.эрсдэлтэй ажил, мэргэжилд шинээр ажилд орох ажилтанд хийх эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн төлөвлөгөөг боловсруулах;

2.3.4.эрсдэлтэй ажил, мэргэжилд шинээр ажилд орох ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулан ажил, мэргэжлийн тохироог үнэлж, ажилд орох үеийн эрүүл мэндийн суурь үзүүлэлтийг хадгалах;

2.3.5.батлагдсан журмын дагуу хийсэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны үнэлгээний тайлан эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэгийн давтамжийг эрсдэлийн ангилал (өндөр, дунд, бага)-д ялгавартай тодорхойлох;

2.3.6.ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулан эрүүл мэндийн эрсдэл, ажил, мэргэжлийн тохирооны үнэлгээ хийх, зөвлөмж өгөх;

2.3.7.шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн хугацаат үзлэгээр илэрсэн мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулуулах, хөдөлмөр зохицуулалтыг хийх;

2.3.8.ердийн өвчний улмаас ажилтан хөдөлмөрийн чадвар алдсан нь тогтоогдвол харьяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлд илгээж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь болон хугацааг тогтоолгох, эрүүл мэндэд эрсдэлгүй ажил хөдөлмөр эрхлэх зөвлөмжийг ажилтан, ажил олгогчид өгөх;

2.3.9.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, эрсдэлийн үнэлгээний үр дүнд дүн шинжилгээ хийж, байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг төлөвлөх.

2.4.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг ажил олгогчийн томилсон эсхүл гэрээт хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч хариуцаж ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн эрүүл ахуйч болон, аюулгүй ажиллагааны ажилтан, бусад мэргэжилтэнтэй хамтран ажиллана.

2.5.Ажилтны эрүүл мэндийн үзлэг хийх эмч нарын багийг хөдөлмөрийн эрүүл мэнд (мэргэжлээс шалтгаалсан өвчин судлаач)-ийн эмч ахалж ажиллана.

2.6.Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад оролцож буй мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн ёс зүйг чанад мөрдөж, ялгаварлан гадуурхалаас ангид, хувь хүний нууц, нэр хүндийг хамгаалж, хөндлөнгийн нөлөөллөөс ангид бие даасан байдлыг хангаж ажиллана

2.7.Ажилтны эрүүл мэндийн мэдээллийн баримт, өгөгдлийг найдвартай хадгалж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хамгаалах бөгөөд ажилтнаас таниулсан зөвшөөрөл авсны үндсэн дээр хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, эрүүл мэндийн судалгааны зориулалтаар ашиглаж болно. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтын зорилгоор боловсруулалт хийж, ажил олгогч, бусад холбогдох талд танилцуулахад хувь хүний мэдээллийг нууцалсан байна.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг

3.1.Эрүүл мэндийн үзлэг нь ажилтны эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой. Эрүүл мэндийн үзлэг нь дараах төрлүүдтэй байна.

3.1.1.эрүүл мэндийн урьдчилсан үзлэг: Ажилтан ажилд орохын өмнөх эрүүл мэндийн үзлэг бөгөөд тухайн ажил гориллогч иргэн гүйцэтгэх ажил үүрэг, ажиллах орчин нөхцөлдөө эрүүл мэндийн хувьд тохирох эсэхийг (сэтгэл зүй болон бие махбодийн хувьд) тодорхойлно.

3.1.2.эрүүл мэндийн хугацаат үзлэг: Ажил үүрэг эсхүл ажлын орчин нөхцөл нь ажилтны одоогийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа эсэх мөн тухайн ажилтны эрүүл мэндийн байдал нь тухайн ажлын байранд тохиромжтой хэвээр байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ажил эрхлэх явцад тодорхой давтамжтайгаар явуулна.

3.1.3.ажилд буцаж орох үеийн үзлэг: Эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас түр завсардсан, мэс засал осол гэмтэл болон бусад өвчлөлийн дараах, эмчилгээ бүрэн дууссаны дараа ажлын байранд эргэн гарахдаа бие махбод, сэтгэл зүйн хувьд үндсэн ажил үүргээ гүйцэтгэхэд тохиромжтой эсэхийг тодорхойлох үзлэг. Тухайн үзлэгээр шаардлагатай тохиолдолд шат дараатайгаар эрүүл мэндэд тохирсон хязгаарлалт зөвлөмж өгнө.

3.1.4.ажлын нөхцөл солих үеийн үзлэг: Ажлын орчин нөхцөл, ажлын байр солих үеийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх ба ижил ажлын байранд шилжиж ажиллах үед өмнөх үзлэгийн хугацаа 6 сараас өнгөрсөн тохиолдолд давтан үзлэгт орно. Тухайн ажилтанд ердийн өвчин болон мэргэжлээс шалтгаалах өвчний хөдөлмөрийн чадвар

алдалт үүссэн тохиолдолд ажил, мэргэжлийн тохироог үнэлэхдээ аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэх бөгөөд хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажил үүргийг хязгаарлах асуудлыг төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэнэ.

3.1.5.ажлаас гарах үеийн үзлэг: Ажилтан нь ажлаас гарах үеийн эрүүл мэндийн байдлыг баримтжуулах ба үзлэгийн баримт бичгийг ажилтан өөрөө хадгалах үүрэг хүлээнэ. Байгууллага ажлаас гарах үзлэгийг хийсэн ба ажилтанд баримт бичгийг хүлээлгэн өгсөн бүртгэл хөтөлнө.

3.2.Ажил олгогч эрсдэлтэй ажил, мэргэжлээр ажиллах ажилтны эрүүл мэндийн үзлэгийг төлөвлөхөд тухайн ажлын байранд тавигдах “Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт”-ийг удирдамж болгоно.

3.3.Ажил олгогч нь ажилд орохын өмнөх эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн үр дүнг ажилтны ажилд орох үеийн эрүүл мэндийн суурь үзүүлэлт болгон хадгалж, хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтад ашиглана.

3.4.Эрсдэлтэй ажил, мэргэжилд шинээр ажилд орох эсхүл эрсдэлтэй ажил, мэргэжлээс 6 сараас дээш завсарласан тохиолдолд эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдаж, ажил, мэргэжлийн тохироог үнэлүүлсэн байна.

3.5.Эрсдэлтэй ажил, мэргэжлээс эрүүл мэндийн шалтгаанаар завсардсан бол ажилд буцаж орох үзлэгт хамрагдаж, ажил, мэргэжлийн тохироог дахин үнэлүүлнэ.

3.6.Ажил олгогч нь эрсдэлтэй ажил, мэргэжлээр ажилладаг ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах төлөвлөгөөг “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам” А/155-ын дагуу хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшнээс хамааран гурав хүртэлх жилийн давтамжтайгаар зохион байгуулна.

3.7.Эрүүл мэндийн үзлэгийн төлөвлөгөө нь дараах агуулгыг хамарсан байна:

3.7.1.эрүүл мэндийн ерөнхий үзлэг, шинжилгээний төрөл;

3.7.2.хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төрөл;

3.7.3.үзлэгийн давтамж

3.8.Ажилтны эрүүл мэндийн үзлэг хийхэд энэ журмын хавсралт 1-д заасан Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн асуумжийг ашиглана.

3.9.Ажилтны эрүүл мэндийн үзлэг хийх эрүүл мэндийн байгууллага нь ажил олгогчоос ирүүлсэн “Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн багц, төлөвлөгөө”-ний дагуу үзлэгийг зохион байгуулж, ажилтан бүрийн ажил, мэргэжлийн тохироог үнэлж, тайланг боловсруулж, ажил олгогчид хүлээлгэн өгнө.

3.10. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн тайлан дараах агуулгатай байна. Үүнд:

3.10.1. Ажил олгогчийн мэдээлэл: нэр, харилцах хаяг, хөдөлмөрийн эрүүл мэндийн асуудал хариуцсан албан тушаалтны мэдээлэл;

3.10.2. Эрүүл мэндийн үзлэг хийсэн байгууллагын мэдээлэл: нэр, харилцах хаяг, үзлэгийн багийн бүрэлдэхүүн, удирдсан хөдөлмөрийн эрүүл мэндийн эмчийн мэдээлэл;

3.10.3. Үзлэгт хамрагдсан ажилтны мэдээлэл: ажлын байр албан тушаал, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны эрсдэлийн мэдээлэл;

3.10.4. Үзлэгийн үр дүн: ажилтнуудын дунд оношлогдсон ердийн өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчин, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд байх, нэмэлт шинжилгээ бүрдүүлж онош тодруулах, хөдөлмөр зохицуулалт хийх тохиолдол;

3.10.5. Ажил олгогчид өгөх зөвлөмж: үзлэгийн үр дүнд үндэслэн хөдөлмөрийн эрүүл мэндийн зөвлөмж;

3.10.6. Ажил мэргэжлийн тохирооны дүгнэлт: үзлэгт хамрагдсан ажилтан бүрээр ажил мэргэжлийн тохирооны дүгнэлт, эмчийн зөвлөгөө болон өндөр эрсдэлтэй ажилтанд өгөх тохиолдлын удирдлага (case management)-ийн зөвлөмж.

Дөрөв. Ажил мэргэжлийн тохироо

4.1. Эрүүл мэндийн урьдчилсан, хугацаат болон ажилд буцаж орох, ажлын нөхцөл солих үеийн үзлэгт хамрагдсан ажилтанд эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээнд үндэслэн үзлэг ажил мэргэжлийн тохироог үнэлнэ.

4.2. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг удирдсан хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч ажилтны ажил, мэргэжлийн тохироог хийхэд энэ журмын 2.3.2-т заасан шалгуур үзүүлэлт, хавсралт 1, 3-ыг удирдамж болгон ашиглана. Мөн үндэсний эсхүл олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эмнэлзүйн удирдамж, мэргэжлийн аргачлал, стандартыг мөрдөж болно.

4.3. Ажил, мэргэжлийн тохироо нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ажилтан тухайн хөдөлмөрийн нөхцөлд ажиллахад бие махбод, эрүүл мэнд, сэтгэл зүйгээр тохирох эсэхийг үнэлж, ажилтны эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой.

4.4. Ажил, мэргэжлийн тохироог үнэлэхэд эмч дараах хувилбарын аль нэгийг сонгоно:

4.4.1. ажилд тохирно: Ажилтан тухайн ажлыг хийхэд тэнцэнэ.

4.4.2. ажилд түр тохирно, нэмэлт үзлэг шаардлагатай: Ажилтан эмчийн тодорхойлсон хугацаанд нэмэлт үзлэг, шинжилгээнд хамрагдах

шаардлагатай ба түр хугацаанд тухайн ажлыг хийх боломжтой. Ажилд тохирох хугацааг эмч тодорхойлно.

4.4.3.хязгаарлалттай тохирно: Ажилтан тодорхой хязгаарлалттайгаар тухайн ажилд тохирох ба нэмэлт, үзлэг шинжилгээнд хамрагдаж, эрүүл мэндийн хувьд эмчийн хяналтад байх шаардлагатай. Тухайн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны эрсдэлийн төвшнөөс хамааран хөдөлмөр зохицуулалт хийж болно.

4.4.4.түр хугацаанд ажлаас чөлөөлнө: Ажилтан эрүүл мэндийн хувьд тухайн ажлыг хийхэд эрсдэлтэй тул нэмэлт үзлэг, шинжилгээ хийсний дараа эсхүл тогтворжуулах эмчилгээ хийсний дараа дахин үнэлэх

4.4.5.ажилд тохирохгүй: Ажилтан тухайн ажлын байранд ажиллах нь ноцтой эрсдэлтэй.

4.5.Ажилтны ажил мэргэжлийн тохирооны үнэлгээний дүгнэлтийг энэ журмын хавсралт 1-т заасан ажилтны эрүүл мэндийн үзлэгийн асуумжийн “Ажил мэргэжлийн тохироо” хэсэгт хийнэ.

4.6.Ажил мэргэжлийн тохироогоор ажилтан тухайн ажлыг гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд тохирохгүй гэж дүгнэгдсэн ч хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч, ажил олгогч, ажилтан гурван тал зөвшилцөн, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой бол ажилтныг хязгаарлалттай нөхцөлөөр ажиллуулж болно. Энэ тохиолдолд эрсдэлийн менежментийн арга хэмжээ, хязгаарлалт, хугацаа, хяналт болон ажилтны аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бичгээр баримтжуулна.

4.7.Ажил, мэргэжлийн тохирооны маргаантай тохиолдлыг мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага эцэслэн шийдвэрлэнэ. Ингэхдээ эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт болон хүлээн зөвшөөрөгдсөн эмнэл зүйн удирдамж, мэргэжлийн аргачлалыг ашиглана.

Тав.Мэргэжлээс шалтгаалсан өвчний оношилгоо, хөдөлмөр зохицуулалт

5.1.Эрүүл мэндийн байгууллага ажилтны эрүүл мэндийн үзлэгээр мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн эсхүл сэжигтэй тохиолдлыг оношилсон бол энэхүү журмын 4.4.1-3 дугаар зүйлийн дагуу тодорхойлж, ажлын 10 өдрийн дотор Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал хариуцсан байгууллагад мэдээлж, онош тодруулахаар илгээнэ.

5.2.Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал хариуцсан байгууллага нь эрүүл мэндийн байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу ажлын 20 өдөрт багтаж мэргэжлээс шалтгаалсан

өвчний онош мөн эсэхийг баталгаажуулна. Нэмэлт үзлэг, шинжилгээ хийхтэй холбоотойгоор энэ хугацааг сунгаж болно.

5.3.Мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг баталгаажуулахад тухайн ажилтны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний тайлан, эмнэл зүйн үзлэг, шинжилгээнд үндэслэнэ. Шаардлагатай тохиолдолд ажил олгогчоос ажилтны хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндийн үзлэгийн талаарх нэмэлт мэдээлэл, баримт бичгийг гаргуулах эсхүл хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээ хийж, эрүүл мэндийн үзлэгт нэмэлтээр хамруулна.

5.4.Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал хариуцсан байгууллага мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг баталгаажуулсан эсхүл үгүйсгэсэн талаарх дүгнэлтийг ажил олгогч болон анх үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллагад ажлын 10 өдрийн дотор багтаж хүргүүлнэ.

5.5.Ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчин оношлогдсон тохиолдолд ажил олгогч тухайн ажилтныг эрсдэлгүй ажлын байранд шилжүүлэх, хөдөлмөрийн зохицуулалтын бусад шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн хэрэгжүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлнэ.

5.6.Хөдөлмөрийн чадвар алдуулсан мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлнэ.

5.7.Эрүүл мэндийн үзлэгээр ажилтанд ердийн өвчний шалтгаанаар хөдөлмөр зохицуулалт хийх шаардлагатай бол ажилтны харьяаллын дагуу эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлд илгээн шийдвэрлүүлнэ.

5.8.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэж, мэдээлэхэд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан журмыг мөрдөнө.

Зургаа. Ажил олгогч болон ажилтны хүлээх үүрэг

6.1.Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахтай холбогдуулан ажил олгогч болон ажилтан дараах нийтлэг үүргийг хүлээнэ.

6.2.Ажил олгогчийн үүрэг:

6.2.1.холбогдох хууль тогтоомж, энэ журмын шаардлагад нийцүүлэн ажилтны эрүүл мэндийн үзлэгийн ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

6.2.2.ажилтны эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай ажилтны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй

ажиллагааны эрсдэл, өмнө хийлгэж байсан үзлэг, шинжилгээний баримт, мэдээллээр үзлэг хийх эрүүл мэндийн байгууллага, хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал хариуцсан байгууллага, бусад холбогдох талыг хангах;

6.2.3.эрүүл мэндийн үзлэгээр тодорхойлогдсон ажил мэргэжлийн тохироог үндэслэн ажилтныг ажилд томилох, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу шаардлагатай хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.2.4.шаардлагатай тохиолдолд ажилтны хөдөлмөр зохицуулалтыг хийж, эрсдэлгүй ажлын байранд шилжүүлэн ажиллуулах;

6.2.5.ажилтанд ажлын байрны нөхцөлөөс хамааран зовуур илрэх, өвчин сэдрэх, өвчлөлийн шинж тэмдэг шинээр илрэх үед үзлэгийн хугацаа, товллол харгалзахгүйгээр эрүүл мэндийн үзлэг хийлгэж, шаардлагатай арга хэмжээг авах;

6.2.6.эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх;

6.2.7.ажилтны эрүүл мэндтэй холбоотой нууцлалыг хуулийн хүрээнд чандлан хадгалах, шаардлагатай бол ажилтны бичгээр үйлдсэн зөвшөөрлийн дагуу хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, онош баталгаажуулалт, эрүүл мэндийн зөвлөмж, шийдвэр гаргуулахад ашиглах, даатгалын нөхөн төлбөр гаргуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сэргээн засах эмчилгээнд хамруулах.

6.3.Ажилтан дараах үүрэг хүлээнэ:

6.3.1.ажил олгогчоос тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны эрсдэл, хувийн эрүүл мэндийн талаарх үнэн зөв мэдээллээр эмчийг хангах;

6.3.2.эрүүл мэндийн үзлэгээр тодорхойлогдсон ажил, мэргэжлийн тохирооны дүгнэлтийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх;

6.3.3.эмчийн зөвлөсөн эрүүл мэндийн зөвлөгөө, зааврыг хэрэгжүүлж өөрийн эрүүл мэндийг хамгаалах, хяналтын үзлэгт товлосон цаг хугацаанд хамрагдах, ажил олгогчид мэдээлэх;

6.3.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дүрэм журмыг мөрдөж, ажил хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх.

Долоо. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад тавигдах шаардлага

7.1.Ажилтны эрүүл мэндийн үзлэг хийх эрүүл мэндийн байгууллага нь үзлэгийн төлөвлөлт, зохион байгуулалт, ажилтны эрүүл мэндийн эрсдэл болон ажил, мэргэжлийн тохироог үнэлэх, эрүүл мэндийн

зөвлөгөө тусламж үзүүлэх мэргэжлийн цогц чадамжийг эзэмшсэн хөдөлмөрийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэшлийн эмчтэй байна.

7.2.Эрүүл мэндийн байгууллага нь ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үзлэг, шинжилгээний төрлөөс хамаарч хөдөлмөрийн эрүүл мэнд болон бусад шаардлагатай төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг үзлэгийн багт ажиллуулна.

7.3.Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төлөвлөгөөгүй тохиолдолд үзлэг хийх эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын 2.3-д заасны дагуу үзлэгт хамрагдах ажилтны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшинд үндэслэн үзлэгийн төлөвлөгөө боловсруулж, асуумж маягыг ашиглаж болно.

7.4.Ажил мэргэжлийн тохироог хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны эрсдэл, үйлдвэрлэлийн орчин нөхцөл, тухайн ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлагын талаар мэдлэгтэй, хөдөлмөрийн эрүүл мэнд, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр мэргэшсэн эмч гаргуулна.

7.5.Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай мэргэжлийн хүний нөөц, баталгаажсан оношилгооны багаж төхөөрөмж, барилга байгууламж, зохион байгуулалтын зохих нөхцөлийг хангасан байна.

Найм. Тайлан, статистик

8.1.Ажилтны эрүүл мэндийн үзлэг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллага дараах тоо мэдээг улирал тутам гаргаж, дараа улирлын эхний 10 хоногт багтаан Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал хариуцсан байгууллагад, Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал хариуцсан байгууллага нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

8.1.1.ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төрөл бүрээр хамруулсан ажилтны тоог эдийн засгийн ангилал, ажлын байрны байршлаар (аймаг, дүүрэг);

8.1.2.хөдөлмөр зохицуулалт хийсэн ажилтны тоог онош, эдийн засгийн ангилал, ажлын байрны байршлаар (аймаг, дүүрэг);

8.1.3.үзлэгээр илрүүлсэн сэжигтэй болон онош батлагдсан мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлын тоог онош, эдийн засгийн ангилал, ажлын байрны байршлаар (аймаг, дүүрэг);

8.2.Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага ажилтны эрүүл мэндийн үзлэг, мэргэжлээс шалтгаалсан өвчний нэгдсэн бүртгэл мэдээллийг хөтөлж, дүн шинжилгээ хийж Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайлагнана.

Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн журмын 1 дүгээр хавсралт

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ХУУДАС

Бүртгэлийн давтагдахгүй дугаар: _____
 Үзлэгийн төрөл: Урьдчилсан ☐ Хугацаат ☐ Ажлын нөхцөл солих ☐
 Ажлаас гарах ☐ Ажилд буцаж орох ☐

НЭГ. АЖИЛТНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1	Овог:	
1.2	Нэр:	
1.3	Төрсөн Огноо (жил сар өдөр):	
1.4	Хүйс:	Эрэгтэй ☐ Эмэгтэй ☐
1.5	Иргэншил:	
1.6	Ажил олгогч байгууллага:	
1.7	Ажлын байрны байршил:	
1.8	Хэлтэс:	
1.9	Албан тушаал:	
1.10	Ажилтны утасны дугаар:	
1.11	Яаралтай үед холбогдох хүний утасны дугаар:	

ХОЁР. АСУУМЖ

Д/д	Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар
2.1	Танд одоо ямар нэг зовиур, эрүүл мэндийн асуудал байгаа эсэх ? Хэрэв тийм бол хэзээнээс эхэлсэн, оношилгоо эмчилгээ хийлгэсэн эсэхийг дэлгэрэнгүй тайлбар хэсэгт бичнэ үү	☐	☐	
2.2	Тогтмол хэрэглэдэг эм, тариа, эмийн бүтээгдэхүүн, байгаа эсэх ? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй тайлбар хэсэгт бичнэ үү	☐	☐	
2.3	Та ажилтай холбоотой осол гэмтэл эсвэл өвчинд өртөж байсан уу?	☐	☐	
2.4	Та урьд өмнө ямар нэгэн хордлого, өвчин эмгэгээр өвдөж байсан уу? Дэлгэрэнгүй тайлбар хийнэ үү	☐	☐	
2.5	Та урьд өмнө өсөл-гэмтэл, мэс ажилбарт орж байсан уу? Дэлгэрэнгүй тайлбар хийнэ үү	☐	☐	
2.6	Та ямар нэгэн зүйлээс харшилдаг уу? (эм, хоол, ургамал гэх мэт) Дэлгэрэнгүй тайлбар хийнэ үү	☐	☐	
2.7	Та тамхи татаж байсан уу, эсвэл татдаг уу? Хэрэв тийм бол: Ямар төрлийн тамхи ? Өдөрт хэдэн ширхэгээр ? Хэдэн жил ?	☐	☐	
2.8	Та архи, согтууруулах төрлийн ундаа хэрэглэдэг үү? Хэрэв тийм бол: 7 хоногт дунджаар ямар хэмжээтэй хэрэглэдэг вэ?	☐	☐	

ГУРАВ. БИЕИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

3.1	Цусны даралт (мм м.у.б)	
3.2	Хэрэв шаардлагатай бол цусны даралтыг дахин хэмжих	
3.3	Пульс/ минутанд, сатураци O_2	
3.4	Амьсгалын тоо/ минутанд	
3.5	Биеийн температур (Цельсээр)	
3.6	Биеийн жин (кг)	
3.7	Өндөр (метр)	
3.8	Биеийн жингийн индекс [жин (кг) / өндөр (м) ²]	
3.9	Бэлхүүс ташааны харьцаа (эрэгтэй < 0.9; эмэгтэй < 0.85)	

ДӨРӨВ. ЛАБОРАТОРЫН БОЛОН БАГАЖИЙН ШИНЖИЛГЭЭ

4.1 ЦУСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ШИНЖИЛГЭЭ (Шинжилгээний хариуг хавсаргана уу)			
4.1.1	Цусны Ерөнхий Үзүүлэлт (Гемоглобин, Гематокрит, Цагаан эс, Неитрофилъ, эозинофилъ, Базофилъ, Лимфоцит, Моноцит, Ялтас эс)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐	
4.2 БИОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ (Шинжилгээний хариуг хавсаргана уу)			
4.2.1	Бөөрний үйл ажиллагаа (Шээсний хүчил, Креатинин, Мочевин, Кали, Натри, Кальци)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐	
4.2.2	Элэгний үйл ажиллагаа (АсАТ/ ГОТ, АлАТ ГПТ, ГГТ, ШФ, Нийт билирубин, Шууд болон шууд бус билирубин, альбумин)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐	
4.2.3	Холестерины түвшин (Нийт Холестерол, Их нягтралтай липопротейн, Бага нягттай липопротейн, Триглицерид)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐	
4.2.4	Цусан дахь сахарын хэмжээ: Өлөн үеийн/ өлөн бус үеийн (доогуур нь зурах)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐	
4.3 ШЭЭСНИЙ ЕРӨНХИЙ ШИНЖИЛГЭЭ (Шинжилгээний хариуг хавсаргана уу)			
4.3.1	Шээсэн дэх цус	Сөрөг ☐	Эерэг ☐
4.3.2	Шээсэн дэх сахар	Сөрөг ☐	Эерэг ☐
4.3.3	Шээсэн дэх уураг	Сөрөг ☐	Эерэг ☐
4.4 СПИРОМЕТР /УУШГИНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СОРИЛ (Шинжилгээний хариу болон спирометрийн асуумжийг хавсаргана уу)			
4.4.1	Уушгины үйл ажиллагааны сорил	Хэвийн ☐ Хэвийн бус ☐	
Эмчийн дүгнэлт:			
4.4.2	Амьсгал хамгаалах хэрэгслийн тохиргооны тест	АХХ-ийн тохиргоо амжилттай тохируулагдсан: Тийм ☐ Үгүй ☐	Үйлдвэрлэгч: Модель: Хэмжээ:
4.5 АУДИОМЕТР (Шинжилгээний хариу болон аудиометрийн асуумжийг хавсаргана уу)			

4.5.1	Сонсголын аппарат хэрэглэдэг үү?	Тийм ☐ Үгүй ☐			
4.5.2	Аудиограммын үр дүн:	Сонсголын аппараттай: Хэвийн ☐ Хэвийн бус ☐ Сонсголын аппаратгүй: Хэвийн ☐ Хэвийн бус ☐			
Эмчийн дүгнэлт:					
4.5.3	Сонсгол хамгаалах хэрэгслийн тохиргооны тест	СХХ-ийн тохиргоо амжилттай тохируулагдсан: Тийм ☐ Үгүй ☐		Үйлдвэрлэгч: Модел: Хэмжээ:	
4.6 ХАРАА					
- Титмус харааны сорилын хариуг бүрэн эхээр нь хавсаргах - Өдрийн хараа/ Шөнийн хараа (шалгасан аргын доогуур зурах)					
	Хараа	Нүдний шилгүй		Нүдний шилтэй	
		Баруун	Зүүн	Баруун	Зүүн
4.6.1	Холын хараа	6/	6/	6/	6/
4.6.2	Ойрын хараа	6/	6/	6/	6/
4.6.3	Шөнийн хараа	6/	6/	6/	6/
4.6.4	Өнгөний хараа (Ishihara Chart)	Хэвийн ☐		Хэвийн бус ☐	
4.6.5	Харааны талбай (Захын хараа)	Хэвийн ☐		Хэвийн бус ☐	
	Стерео хараа	Хэвийн ☐		Хэвийн бус ☐	
Эмчийн дүгнэлт:					

ТАВ. ЭРХТЭН ТОГТОЛЦООНЫ ҮЗЛЭГ

5.1 ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦОО: Үзлэг хийж байгаа эмч бөглөх хэсэг.		
5.1.1	Та зүрх судасны эмгэгээр өвдөж байсан/өвддөг үү? (зүрхний шигдээс, зүрхний хагалгаа, зүрхний агшилтын үеийн шуугиан, зүрх дэлсэх, хэм алдагдал, цээжний бах, зүрхээр өвдөх, алхах эсвэл шатаар өгсөх, эсвэл хэвтэх үед амьсгааддаг эсэх, эсвэл зүрхний бусад өвчин зовиурууд бий эсэх)?	Тийм ☐ Үгүй ☐
5.1.2	Таны даралт ихэсдэг үү?	Тийм ☐ Үгүй ☐
5.1.3	Танд гүний вений тромбоз эсвэл уушигны эмболи оношлогдож байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.1.4	Бодит үзлэгээр өөрчлөлт илэрч байгаа эсэх? (Зүрхний хэмнэл, захын пульс, зүрхний шуугиан, зүрхний дутагдлын шинж тэмдэг/хаван, өргөссөн венийн судас)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
5.1.5	ЗЦБ (хэрэв 40-өөс доош насныханд үзлэгээр эмгэг илэрсэн бол) Тайлбар:	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
5.1.6	Зүрх судасны эрсдлийн нэмэлт тодруулга (50-аас дээш нас эсвэл үзлэгээр эмгэг илэрсэн хүмүүс) : ХАВСРАЛТ-аар Зүрхний титэм судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийг урьдчилан таамаглах хүснэгтийг хавсаргана уу.	

Эмчийн дүгнэлт:

5.2 АМЬСГАЛЫН ЗАМЫН ЭРХТЭН ТОГТОЛЦОО: *Үзлэг хийж байгаа эмч бөглөх хэсэг.*

5.2.1	Та уушгины эмгэгээр өвдөж байсан/өвддөг үү?	Тийм ☐ Үгүй ☐
5.2.2	Та урьд өмнө Бронхит/Гуурсан хоолойн багтраа/ Сүрьеэгээр өвдөж байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.2.3	Бодит үзлэгээр өөрчлөлттэй эсэх? (амьсгалын зам саадгүй эсэх, тайван үед шуугиантай эсэх, чагналтаар эмгэг өөрчлөлттэй эсэх)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐

Эмчийн дүгнэлт:

5.2.4	Мэргэжлээс шалтгаалах уушигны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлох, онош баталгаажуулах эсвэл үгүйсгэх зорилгоор олон улсын мэргэжилтэнээр дүгнэлт гаргуулах шаардлага гарч болох тул ажилтнаар “Таниулсан зөвшөөрлийн маяг”-ыг бөглүүлэх шаардлагатай.	
5.2.5	ЦРЗ дүгнэлт хийсэн:	

Дүрс оношлогооны эмчийн дүгнэлт:

5.3 ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН ТОГТОЛЦОО: *Үзлэг хийж байгаа эмч бөглөх хэсэг.*

5.3.1	Танд ходоод гэдэсний хямрал, өвдөлт/улайлт/ шархлаа/ хэвлийн Тийм Үгүй өвдөлт зэрэг эмгэгүүд оношлогдож байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.3.2	Танд цусаар бөөлжих эсвэл өтгөн хар өнгөтэй гарах шинжүүд илэрч байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.3.3	Та урьд өмнө элэгний эмгэгээр өвдөж байсан уу (гепатитыг оруулан)?	Тийм ☐ Үгүй ☐
5.3.4	Хэвлийн бодит үзлэгээр өөрчлөлттэй эсэх? (сорви, тууралт, үүсгэвэр, ивэрхий гэх мэт)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐

Эмчийн дүгнэлт:

5.4 ЯС БУЛЧИН, БИЕ БЯЛДРЫН ЧАДАВХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ: *Үзлэг хийж байгаа эмч бөглөх хэсэг.*

5.4.1	Танд яс, булчин, үений эмгэгүүд илэрч байсан эсвэл байгаа юу? (Хүзүү, нуруу, мөр, тохой/ бугуй/ гар, ташаа, түнх, өвдөг, шагай/ хөл) доогуур зурах.	Тийм ☐ Үгүй ☐
5.4.2	Таны хүзүү болон нуруу өвддөг эсэх, өвдөлтөөс болж ажлын чадвар буурдаг эсэх ? Өвдөлтөөс болж ажлын нөхцөлөө сольж байсан эсэх ?	Тийм ☐ Үгүй ☐
5.4.3	Нуруу нугас: Сколиоз, Хүзүүний/Цээжний/Бүсэлхийн нугаламын бүтэн хөдөлгөөн, Байр байдал/Алхаа гишгээ, Хөлийн шулууны тест, Өлмий, өсгийн алхаа (доогуур зурна уу)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐

5.4.4	Дээд мөч: Булчингийн/Хүч, Хөдөлгөөний далайц, Рефлекс, Бугуйн сүвгийн хам шинж? (доогуур зурна уу)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
5.4.5	Гар-шуунд дамжих доргионы өвчний шинж тэмдэг илэрсэн эсэх? Хэрэв тийм бол ХАВСРАЛТ-аар асуумжийг хавсаргана уу	Тийм ☐ Үгүй ☐
5.4.6	Доод мөч: Булчингийн/Хүч, Хөдөлгөөний далайц, Рефлекс, Өрөөсөн хөл дээрээ ачаалал авах чадвар, Явган суух чадвар (доогуур зурна уу)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
5.4.7	Бие бялдрын чадавхийн үнэлгээ: ХАВСРАЛТ-аар хариуг хавсаргана уу	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
Эмчийн дүгнэлт: (мэс заслын сорвины тайлбар, булчингийн хатингаршил гэх мэт):		

5.5 МЭДРЭЛИЙН ТОГТОЛЦОО болон СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД: Үзлэг хийж байгаа эмч бөглөх хэсэг		
5.5.1	Танд мэдрэлийн эмгэг оношлогдож байсан/ байгаа юу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.2	Танд манасхийх/ухаан балартах/толгой манарах/ толгой эргэх/ тэнцвэр алдагдах шинжүүд илэрч байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.3	Та ухаан алдаж, уналт таталт өгөх эсвэл эпилепсигээр оношлогдож байсан уу	Тийм ☐ Үгүй ☐
5.5.4	Та тархи эсвэл нугасны гэмтэл авч байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.5	Танд гар хөл ирвэгнэж бадайрах, өвдөх, хатгах шинжүүд илэрч байсан уу? Эсвэл гар хөл нь суларч мэдрэхүй буурах, тэнцвэр алдагдах зовиур илэрч байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.6	Та өмнө нь тархинд цус харвалт болон тархины судасны түр зуурын дайрлагаар оношлогдож байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.7	Тэнцвэр, нийцэл, Төв мэдрэлийн систем, бусад (доогуур зурна уу)	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
5.5.8	Танд сэтгэцийн эмгэг оношлогдож, эмчилгээ хийлгэж байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.9	Танд өмнө нь сэтгэцийн эмгэг байдал илэрч эмчилгээ, зөвөлгөө авч байсан уу (сэтгэл зовнил, сэтгэл гутрал, стрессийн хүнд хэлбэр, амиа хорлохыг завдах гэх мэт)?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.10	Танд яг одоо сэтгэлзүйн тулгамдсан асуудал, бүхимдал, стресс, сэтгэл санаа түгшээсэн асуудал байна уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.11	Үзлэгийн үеийн зан байдал, хэл яриа	Хэвийн ☐ Хэвийн бус ☐
5.5.12	Сэтгэцийн талаас ямар нэг эмгэг, хэвийн бус байдал илэрсэн эсэх?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.13	Танд нойргүйдэл, нойрны эмгэг байдаг уу?	Тийм ☐ Үгүй ☐

5.5.14	Шөнө нойр хүрэхгүй байх эсвэл нойр ханахгүй унтаад баймаар үе байдаг уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.15	Шөнөжин унтсан боловч өглөө сэрэхэд нойр ханаагүй, бие амраагүй ядарсан хэвээр байдаг.	Тийм ☐ Үгүй ☐
5.5.16	Орондоо орсноос хойш цагаас дээш хугацаагаар хөрвөөж байж унтдаг.	Тийм ☐ Үгүй ☐
5.5.17	Та нойрны өвчин, нойрсолтын апноз/амьсгал тасалдах/ эсвэл нарколепси/хэт нойрсох/ гэж оношлогдож байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.5.18	Хэн нэг нь танд унтаж байхдаа амьсгал чинь тасалдаад байна гэж хэлж байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
Эмчийн дүгнэлт: (бодит үзлэгээр өөрчлөлттэй эсэх)		

5.6 БУСАД ЭРХТЭН ТОГТОЛЦОО: Үзлэг хийж байгаа эмч бөглөх хэсэг.		
5.6.1	Танд дотоод шүүрлийн булчирхайн эсвэл бодисын солилцооны эмгэг байгаа юу? (чихрийн шижин, бамбай булчирхайн гэх мэт)	Тийм ☐ Үгүй ☐
5.6.2	Сүүлийн 12 сард шалтгаангүй огцом жин буурсан тохиолдол бий юу (жишээ нь 5кг-аас илүү)?	Тийм ☐ Үгүй ☐
5.6.2.1	Та өмнө нь ямар нэг хорт хавдраар өвдөж байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
5.6.3	Та өмнө нь цусны ямар нэг эмгэгээр өвдөж байсан уу (цус багадалт, цусны цагаан эсийн хавдар, цус бүлэгнэлтийн алдагдал, тромбоз /судасны бөглөрөл/ гэх мэт)?	Тийм ☐ Үгүй ☐
5.6.4	Танд эмчлүүлэх шаардлагатай шүдний өвчин байгаа юу ?	Тийм ☐ Үгүй ☐
5.6.5	Та нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх/эмийн болон мэс ажилбар/мэс засал хийлгэхээр төлөвлөж байгаа юу?	Тийм ☐ Үгүй ☐
5.6.6	Та өмнө нь бөөр эсвэл давсагны үрэвсэл /халдвар/, чулуу, хатгалгаа (колик)-аар өвдөж байсан уу?	Тийм ☐ Үгүй ☐
